



АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2019/04



www.nso.mn www.arkhangai.nso.mn www.1212.mn




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 99 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 109.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 38.8 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 7.3 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.8 хувийг хамруулсан бол Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100.0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Оны эхний 4 сард 546 эхээс 547 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 9.1 хувиар буюу 55 хүүхдээр бага байна.

Хүн амын нас баралт 181 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1 тохиолдлоор их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 5.7, нас баралт 1.9 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 3.8 промил байна. Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл 1 гарч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3, нялхсын

буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 6 гарч мянган амьд төрөлтөд 11 ногдож байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 18 нь буюу 172 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган(85), Хотонт (9), Тариат (9), Өндөрүлаан (8), Цэнхэр (8) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 15.1 хувь нь салхин цэцгээр, 55.8 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 6.4 хувь нь сүрьеэгээр, 22.7 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 2 тохиолдлоор нэмэгдсэн байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР


5 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1238 ажилгүй хүн байгаагийн 48.5 хувь нь буюу 601 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 211 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 8.2 хувиар багассан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 99.0 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 191 нь дээд, 64 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 914 нь бүрэн болон бүрэн бус дунд, 56 нь бага боловсролтой хүмүүс байна.

4 дүгээр сард ажилгүйчүүдийн бүртгэлд 64 хүн шинээр бүртгүүлж, 46 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж 5 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Оны эхний 4 сарын байдлаар аймагт 119 шинэ ажлын байрыг бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 29, Хотонт сум 20, Батцэнгэл, Булган, Жаргалант, Өндөр-улаан, Тариат, Цэнхэр, Цэцэрлэг, Хашаат, Хайрхан, Өлзийт, Эрдэнэмандал сумдууд 5-6 ажлын байр, Өгийнуур, Цахир, Хангай сумд 2-4 ажлын байрыг бий болгожээ.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо






НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 4 сард 19.6 тэрбум төг, зарлага 18.9 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 2782 сая төг буюу 16.6 хувиар, зарлага 2962.7 сая төг буюу 18.5 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 2782 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын санг 16.8 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 6.6 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 18.8 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 43.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 18.5 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сан 15.4 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 8.3 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 76.2 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 39.2 хувиар өссөн нь шууд нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 16.9 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 641 сая төгрөгийг олгосон байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц



Оны эхний 4 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 35.5 мянган хүнд 5118 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон

байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 46 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, 54 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.


Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 58 хувийг халамжийн тэтгэврээр, 33 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 9 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлтөд зарцуулж байна.



ГЭМТ ХЭРЭГ


Аймгийн хэмжээгээр 89 хүн гэмт хэрэгт холбогдож 215 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 59, өмчлөх эрхийн эсрэг 122, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 15, байгаль хамгаалах журмын эсрэг 4, бусад 15 хэрэг гарсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас 12 хүн нас барж, 63 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 625.2 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 8.4 хувийг бүлэглэж

10.6 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 247 хүнийг албадан саатуулж 101 хүнийг баривчилсан байна.



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2.8 хувиар буюу 6 тохиолдлоор өссөний дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 15 тохиолдлоор буюу 20.2 хувиар буурсан бол өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 11.5 хувиар буюу 14 тохиолдлоор, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 тохиолдлоор тус тус өссөн байна.



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2019 оны эхний 4 сард аймгийн төсөвт 5839 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 6630.1 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 113.5 хувиар биелүүлсэн байна.


Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 2026.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2817.2

сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 139 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Батцэнгэл, Жаргалант, Өлзийт, Төвшрүүлэх, Хайрхан, Хотонт Цахир, Цэцэрлэг, Чулуут сумдаас бусад сумд 106.8 хувиас 2.4 дахин биелүүлсэн байна.

Орлогыг нэр төрлөөр нь үзвэл төсөвт байгууллагын өөрийн орлого, газрын төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжаас бусад нэрийн орлогуудыг 112.2 хувиас 2.0 дахин биелүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын 57.5 хувийг тусламжийн орлогоор, 30 хувийг орлогын албан татвараар, 1.2 хувийг өмчийн татвараар, 2.5 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 3.9 хувийг бусад албан татвараар, 4.3 хувийг татварын бус орлогоор, 0.6 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.


Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 88.3 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 302.2 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 11.6 сая төгрөг бүгд 402.1 сая төгрөгийг шилжүүлж даалгаврыг 132.7 хувиар давуулан биелүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 20116 сая төгрөг байгаагийн 62.1 хувийг цалин хөлсөнд, 7.7 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 30.2 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 23.0 хувийг орон нутгийн засаг захиргаанд, 64.1 хувийг боловсролын салбарт, 11.6 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.8 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0.5 хувийг хүн ам нийгмийн хөгжлийн салбарт зарцууллаа.

Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар




МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ



Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 15.8 тэрбум төгрөгийг авч 13.7 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 4 сард банкууд 20.8 мянган иргэд, аж ахуй нэгжид 40.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 4 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 30.7 хувиар өссөн бол, олгосон зээлийн хэмжээ 9.4 хувиар буурсан байна. Харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 20.4 хувиар буурсан бол, чанаргүй зээлийн хэмжээ 98.1 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2019 оны 4 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0.3 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.8 хувиар, 2018 оны 12-р сарынхаас 2.2 хувиар хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 3 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 373 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын хувийнх нь 9.7 өсч, 6.2 хувийнх нь үнэ буурч 84.1 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас дотор мах, лууван, сонгино, төмс, хүүхдийн трико, түлшний мод, хөвөн, алим, үзэм зэргийн үнэ 0.2 - 8.5 хувиар буурч харин тахиа, адуу, хонь, үхрийн мах, пиво, гурил, манжин, шоколад, гүрж ногоон цай, эмэгтэй хослол зэргийн үнэ 0.2 – 10.8 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 15 хувийнх нь буюу 56 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 32.2 хувийнх нь буюу 120 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 52.8 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс дотор мах, өөхөн тос, манжин, лууван, масло, цагаан будаа, оймс, угаалгын нунтаг, ор хөнжлийн даавуу, түлшний мод зэргийн үнэ 0.1 - 64.2 хувиар буурч харин хонь, үхэр, адуу, ямааны мах, аарц, шар будаа, ургамлын тос, гар нүүрийн саван, орны бүтээлэг сахлын татуурга, кабелийн телевизийн хураамж, ноосон болон даавуун цамц зэрэг барааны үнэ 0.1 – 75.0 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

4 дүгээр сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 69 хувь нь буюу 1633 мянган эх мал төллөж гарсан төлийн 98.2 хувь нь буюу 1603.3 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 100 хувь, унаганы 96.0 хувь, тугалын 97.4 хувь хурганы 98.6 хувь, ишигний 97.4 хувь нь бойжиж байна


Төл бойжилтын хувь



Сумдаас Төвшрүүлэх, Өгийнуур сумд гарсан төлөө 100 хувь бойжуулж байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 22.7 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 26.7 хувиар их, төлийн хорогдол 45.4 хувиар бага байна.

Эхний улирлын байдлаар оны эхний мал 99.6 хувиар онд орж оны эхний малын 0.4 хувь буюу 21.8 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 7.4 хувийг адуу, 12.5 хувийг үхэр, 42.9 хувийг хонь, 37.2 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр




Сумдаас Жаргалант, Цахир, Ихтамир, Цэнхэр, Цэцэрлэг, Өндөр-улаан, Тариат, Хангай, Эрдэнэбулган, Булган сумдын оны эхний малын 0.5- 0.8 хувь нь, Өлзийт, Хайрхан, Чулуут, Эрдэнэмандал, Батцэнгэл сумдын оны эхний малын 0.4 - 0.2 хувь нь хорогдсон бол Өгийнуур, Төвшрүүлэх, Хашаат, Хотонт сумдад том малын хорогдол гараагүй байна.

2019 онд манай аймаг ойгоос 93.2 мянган м³ галын түлээ, 10.6 мянган м³ хэрэгцээний мод, бүгд 103.8 мянган м³ мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 4 сард 24.2 мянган м³ галын түлээ, 4.2 мянган м³ хэрэгцээний мод, бүгд 28.4 мянган м³ мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 84.2 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2019 оны эхний 4 сард оны үнээр 2629.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2496.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оныхоос 4.3 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 915.5 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.7 хувиар их байна.



Нийт үйлдвэрлэлтийн 8.9 хувийг хүнс ундааны, 1.0 хувийг хэвлэлийн, 69.7 хувийг дулааны эрчим хүчний, 10.6 хувийг усан хангамж, 2.6 хувийг модон эдлэлийн, 6.2 хувийг гутал хувцасны, 0.1 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэрчсэн гурил, дулаан, вакуум цонх, эмээлийн мод, бууз, хүснэгт маягт, зүсмэл, монгол гутлын үйлдвэрлэл 2.6 – 324.3 хувиар нэмэгдлээ. Харин түгээсэн цэвэр ус, монгол дээлний үйлдвэрлэлийн хэмжээ 19.9 – 24.7 хувиар буурсан байна.

Тээврийн байгууллагууд 15.1 мянган зорчигч, 5.8 мянган тонн ачаа тээвэрлэн 6.9 сая хүн км, 2.3 сая ткм ажил гүйцэтгэн 237.9 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн

оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт 14.7 – 14.1 хувиар буурсан бол ачаа, эргэлтийн хэмжээ 60.8-70.6 хувиар нэмэгдлээ.

Холбооны байгууллагууд 398 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 112.8 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 35 хувиар нэмэгдсэн байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

4 дүгээр сард агаарын дундаж температур 1.4-өөс 6.1 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Хашаат, Хайрхан, Батцэнгэл, Хотонт, Өгийнуур сумдад 21.0 – 22.0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Өндөрүлаан, Булган, Хашаат сумдад –12.0-аас –15.0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Өндөр-улаан, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Өлзийт, Төвшрүүлэх, Булган, сумдын нутгаар 13.1- 25.4 мм хур тундас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хангай, Жаргалант, Өгийнуур, Хашаат сумдад 0.9 – 3.4 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2019.05.10